

**“ЧАНДМАНЬ-БАЯНХОНГОР” ХХК-ИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН
ХЭРЭГЖИЛТ**

2025 оны 12 дугаар сарын 23-ны өдөр

Номгон

№	Тэргүүлэх чиглэл	Хэрэгжилт	Хувь
1	Инженерийн шугам сүлжээ, уурын зуухны бэлтгэл ажлыг хийсэн байдал	Ус хангамж, ариутгах татуургын алба: 1. Ус хангамжийн эх үүсвэрт Мастра 10 SP125-.03 маркын насосыг 8,4 саяаар нөөцөнд авч ус хангайжийн үйл ажиллагааны найдвартай ажиллагааг бүрдүүлсэн байна. 2. 2025 оны 04 сарын 15-аас эхлэн 5 дугаар сарын 20 –ны хооронд хаврын ээлжит лайдалт, цэвэрлэгээг хийж, ариутгах татуургын шугам сүлжээний хэвийн ажиллагааг хангаж ажиллалаа. 3. Соого Сейко, 2-р цэцэрлэгийн чиглэлийн Ф76мм-ийн ган хоолойг Ф100 мм-ийн HDPE маркын хуванцар хоолойгоор 250м шугам сүлжээг шинэчилсэнээр шугам хоолойн насжилт нэмэгдэж, хэрэглэгчийн даралт нэмэгдсэн байна. 4. 5.6-р багийн төвийн дахин дамжуулахын шугам сүлжээг Ф150мм-ийн шугамыг шинээр тавьж, багийн төв болон идахин дамжуулахыг цэвэр усны системд холболоо. 5. Хонгор гарден чиглэлийн цэвэр усны 105 м шугам хоолойг Ф100мм цайран ган трубагаар шинэчилж, хэрэглэгчийн усны даралтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн шугам хоолойн засвар хийгдлээ. Нийт 365 м шугам хоолойн ажлыг хийхэд 29,213,660 төгрөг зарцуулсан 6. Төв магистрал Ф400мм- ийн шугам сүлжээг шинэчлэн хэвийн ажиллагааг хангасан байна. 5-р сургуулийн чиглэлийн Ф200мм-ийн шугамыг 60м газарт шинэчилсэн. 7. Политехникийн коллежийн ард байрлах 100 дугаар байрны чиглэлийн Ф200мм-ийн 60м шугам сүлжээг шинэчилсэн 8. 2-р цэцэрлэгийн чиглэлийн салбар 120м шугам сүлжээг Ф150 мм болгон шинэчилсэн Бохир усны шугам сүлжээг шинэчлэхэд 24,671,719 төгрөг зарцуулжээ. Дулаан хангамжийн хэсэг: 1. 2025 оны 01 сараас 12 сарын 20 хүртэл 4,138 тн нүүрсийг татан төвлөрүүлж, 7 халаалтын зуухны хэвийн ажиллагааг хангаж, харьяа зуухнаас халаалт авдаг иргэдийн ая тухтай амьдрах боломжийг бүрдүүллээ. 2. 5,6-р багийн халаалтын зуухыш ашиглалтад оруулж, туршилт тохируулгыг хийж, DZLмаркын 2 ш тогооны галалгааг жигдрүүлэн явуулж, дулааны	100%

		хүчин чадлыг нэмэгдүүлсэнээр шинээр хэрэглэгчийг холбох боломж бүрдэж байна. 3.Есөн-Эрдэнэ захын усан халаалтын БЗИУ 100 -ын 2 тогоо гадна өрлөг 12 ханыг галд тэсвэртэй SK-34 маркийн тоосгоор өрөв. 4.10-р багийн шинэ төгөл хотхон уурын зуухны барилгын дээврийг сэргээн засах ажлыг хийж гүйцэтгэв. 5.9-р багийн шинэ төгөл хотхон уурын зуухны нүүрс буулгах талбай $5,5\text{м}^3$ бетоноор 24м^2 -ыг цутгалт хийв. 6. 9-р багийн 11-р цэцэрлэгийн зуухны хашаа үнс, хог цэвэрлэх ажлыг хийж 42 тн үнс , 84 тн нүүрсний чулуу хог хаягдлыг зориулалтын цэгт буулгаж, ажлын талбайг цэвэрлэв. 7. Авто машины гражийн халаалтын нэмэлт секц гагнах ажлыг хийж гүйцэтгэж, өвлийн улиралд машин механизм, техникийн бэлэн байдлыг хангах ажлыг хийв. 8. 9-р багийн зуух шинэ төгөл хотхон, 1-р багийн төв зуухнуудын хашаа сэргээн засварлах ажил хийж ажиллаа. 9. Есөн –Эрдэнэ захын халаалтын зуухны дотор схемийг өөрчилж тохируулга хийснээр дулаан түгээлтийн найдвартай байдлыг сайжруулсанаар төгсгөлийн 8 хэрэглэгч халж иргэдийн гомдлыг барагдууллаа. 10. Гийх наран хороололын шугам сүлжээг 120 м шинэчилж, өргөтгөлөө. 10. Байгууллагын үйлчилгээний 18 тээврийн хэрэгслийн бэлэн байдлыг хангахад 48,8 сая төгрөг зарцуулж сэлбэг хэрэгслийг шинэчлэн сольсон байна. Цэвэр ус зөөврийн 3 автомашин, нүүрс зөөврийн 2 автомашин, шуурхай үйлчилгээний автомашинд шаардлагатай сэлбэгийг тавьж, үйл ажилллагааг жигдрүүлэн явж байна. /100%/	
2	Шугам сүлжээний усны алдлагдлыг бууруулах талаар хийгдсэн ажил	1. Ус хэрэглэгч аж ахуйн нэгжид хяналт, шалгалт хийж, 17 аж ахуйн нэгжид ухаалаг тоолуур суурилуулсан. 2.Орлого болоогүй усны алдагдлыг бууруулахад дотоодын хэрэглээг бодитоор тооцохоор Есөн-Эрдэнэ ахын цэвэр усны хэрэглээний шугамд тоолуурыг суурилуулсан. 3. Айл өрхийн тоолуурын бичилтэнд хяналт тавихаар 2025 оны 05 сарын 14-ны өдрийн “Хэрэглэгчдэд түгэсэн борлуулсан усны бичилтэнд хяналт тавих ажлын удирдамж” –ийг боловсруулан айл өрхүүдээс түүвэрлэн авч, бичилт хийгдсэн тоолууранд хяналт тавилаа. 4. Дулаан хангагч 14 байгууллагад цэвэр усны тоолуур суурилуулах албан мэдэгдэл хүргүүлсэн. Хэрэглэгчдэд суурилуулах тоолуурыг урьдчилан захиалсан болно. 5. Цэвэр усны тоолуурын гацалт, гэмтэлтэй холбоотой 60 дуудлагыг хүлээж авч, ажилласан ба 22 хэрэглэгчдэд шинээр тоолуур суурилуулж, 14	100%

		хэрэглэгчийн тоолуурт үзлэг шалгалт хийсэн байна. 2025 онд Эх бүрдэн ХХК, "Фюм" ХХК, "RMB" ХХК, "Хөвших хайрхан" ХХК, "Марал гүн" ХХК-ийн хариуцан үйл ажиллагааг явуулдаг халаалтын зуухны цэвэр усны шугамд Ф50мм –ийн тоолуурыг суурилуулсан. Эдгээр халаалтын зуухны цэвэр усыг тоолуур усыг тооцож үзэхэд 2025 оны 09-11 дүгээр сар хүртэл 3680м3 усны зөрүүг нэмэлтээр тооцож тухайн ус ашиглагчдаас авсан болно.	
3	Өргөдөл гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэсэн байдал	Баянхонгор хотын цэвэр усны 34км, бохир усны 33км шугам сүлжээний ашиглалтыг хариуцан ажиллаж байна. 2025 онд хэрэглэгчээс 3136 дуудлагыг хүлээн авч, засвар үйлчилгээ хийж ажиллалаа. Айл өрхөөс 1612 дуудлага ирсэнээс цэвэр усны гэмтэл 941, ариутгах татуургын шугам сүлжээтэй холбоотой 671 дуудлагыг барагдуулж ажилласан. Аж ахуйн нэгж байгууллагаас ирсэн 666 дуудлагыг барагдуулж, гүйцэтгэсэн ба цэвэр усны 156 дуудлага, ариутгах татуургын тоног төхөөрөмжийн 510 гэмтлийг засварласан байна. Оросууцны дундын эзэмшлийн шугам сүлжээтэй холбоотой 147 дуудлага барагдуулж, нийт орон сууц, аж ахуйн нэгжтэй холбоотой 2425 дуудлагыг барагдуулж ажилласан байна. Төв болон салбар шугаманд гарсан 132 гэмтлийг засварлаж хэвтийн ажиллагаанд орууллаа. Цэвэр усны шугам сүлжээнд 6 гэмтэл, бохир усны шугам сүлжээнд 119 гэмтэл гарсныг засварлаж ажиллалаа. Ариутгах татуургын төв шугам сүлжээ нь 7 удаа томоохон гэмтэл гарсныг засварласан байна. 2025 онд хэрэглэгчээс бичгээр ирсэн 125 өргөдлийг шийдвэрлэсэн.	100%
4	Гэнэтийн болон байгалийн давагдашгүй хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх ажлыг шуурхай зохион байгуулж, иргэд, ААН-ийг цэвэр усаар тасралтгүй хангах эрсдэлийн төлөвлөгөөний хэрэгжидт	2025 оны эхний хагас жилд 4 томоохон гэмтэл гарахад авар зарлан ажиллаж, хэвийн ажиллагаанд оруулллаа. 1.2025.10.25-ны өдөр ариутгах татуургын Ф400мм төв шугамд гэмтэл гарсныг 56 цагийн турш шуурхай зарлаж хэвийн ажлилагаанд оруулав. 2.2025.01.25-ны өдөр ус хангамжийн гүний насосонд гэмтэл гарсныг шуурхай засварлаж ажиллагаанд оров. 3.2025.05.08-нд Шинэ суурьшлийн бүсийн усан сангийн түгээх шугамд гэмтэл гарсныг аваарыг шуурхайн засварчид ажиллаж хэвийн ажиллагаанд оруулав. 4.2025.06.22-ны өдөр цэвэр усны төв шугамд хаалт задарч, гэмтэл гарсныг шуурхай зарлан хэвийн ажиллагаанд оруулж, иргэдийг цэвэр усаар хангасан болно. 5. 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдөр бохирусны төв шугам дээр гарсан гэмтэлд Шуурхай хэсгийн 8 засварчин болон инженер	100%

		техникийн ажилчид 18 цаг ажиллаж нэмтлийг арилгалаа. 6. 2025 оны 11 дүгээр сарын 13 ны өдөр цэвэр усны төв шугамд гарсан гэмтлийг Инженер техникийн ажилчид болон Шуурхай хэсгийн засварчид, 3 техниктэйгээр 24 цагийн ажиллаж гэмтлийг сэргээн засварлалаа.	
--	--	--	--

Фото зургийг хавсаргав.

ХЯНАСАН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.СОРОНЗОНБААТАР

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

ДОТООД ХЯНАЛТ, ТОГТООЛ

ШИЙДВЭР ХАРИУЦСАН АЖИЛТАН

С.ИДЭРЦЭЦЭГ

